



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 11167

Номгон

Гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдлыг  
хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "б", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар бүлгийн 2.1.1, 2.1.2, 3 дугаар бүлгийн 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд коронавирус (COVID-19)-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, өвчний хор уршигтай тэмцэх бэлтгэл, бэлэн байдлыг хангаж байгаатай холбогдуулан аймгийн Цагдаагийн газрын шуурхай албаны 00-02 БНХ улсын дугаартай Ланд-200 загварын автомашины мотор солиход 28,000,000 (Хорин найман сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Байгалмаа/-т зөвшөөрсүгэй.

2. Шуурхай албаны машиний бэлэн байдлыг хангаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга хурандаа (Б.Оюутболд)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Д.Сарангараав)-д даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН